


Ковид-19 цар тахлын үед болсон голлох үйл явдлууд, он цагийн дарааллаар



Төрөөс авч хэрэгжүүлсэн голлох шийдвэр болон эрх зүйн үндэслэл

- 2020.02.12 – 62-р тогтоол - “Гамшгаас хамгаалах Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт” шилжсэн.
- 2020.04.09 – КОВИД-19-ийн хуулийн төслийг баталсан
- 2020.05.14 - Гамшгаас хамгаалах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.



Цар тахлын үеийн засаглал

Засаглал, эрх мэдлийн төвлөрөл



Төрийн байгууллагуудын уялдаа холбоо сул байдал



Төлөвлөгөөгүй, тооцоо судалгаагүй шийдвэр, үйл ажиллагаа



Монголын цар тахлын засаглалын талаарх шүүмжлэл дагуулсан асуудлууд

Хүний эрхийн зөрчил

- Албан хаагчдын хүнлэг бус харилцаа гарсан
- Нийгэм-эдийн засгийн тэгш бус байдал гүнзгийрсэн
- Гэр бүлийн хүчирхийлэл гарсан
- 21 хоногийн тусгаарлалтаас шалтгаалсан асуудлууд
- Хилийн хоригоос шалтгаалсан асуудлууд
- УОК-ийн шийдвэрүүдээс шалтгаалсан асуудлууд
- Хуулийн хэрэгжилт ялгамжтай



Засаглалын тэнцвэр, хариуцлагын тогтолцоо

- Засгийн газрын эрх мэдлийг нэмэгдүүлсэн, ЗГ-т төсвийн зохицуулалт хийх эрх олгосон
- Цахилгаан, дулаан, усны төлбөрийг төр хариуцсан
- Иргэн бүрд 300 мянган төгрөг, вакцин хийлгэсэн иргэн бүрд 50 мянган төгрөг олгосон
- 2020 онд нийт 3.6 их наяд, 2021 онд 10 их наяд төгрөгийн алдаа зөрчил гаргасан нь аудитаар илэрсэн
- Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль баталсан
- Төрийн албаны тухай хуулийн сонгон шалгаруулалтыг түдгэлзүүлсэн



Сонгууль

- Тусгаарлалтад буй сонгогчдын сонгох эрхийг хязгаарласан
- КОВИД хязгаарлалтын үед сонгууль зохион байгуулсан нь эрх баригчдад давуу эрх олгосон
- Бүх баяр ёслол, олон нийтийн арга хэмжээг цуцалсан боловч 3 шатны сонгууль зохион байгуулсан



Цахим эрх

- Иргэдийн хөдөлгөөн, хавьтлыг мөшгөж, хянасан
- E-barimt систем дээр суурилсан QR код-оор дамжуулан хянасан
- Эерэг тохиолдолтой хавьтал болсон хүмүүст шуурхай мэдээлсэн – Apple & Google
- Дрон ашиглан иргэдийн хөдөлгөөнийг хянасан
- Хүний хувийн ямар мэдээлэл ашиглаж байгаа талаар мэдээлэл өгөөгүй
- Мэдээллийн аюулгүй байдлын талаар ойлголт өгөөгүй

Цар тахлын үеийн шийдвэрүүдийн тойм



Нийт 1,312 шийдвэр

1,109

160

43

Шинээр батлагдсан

Нэмэлт өөрчлөлт орсон

Хүчингүй болсон

Эдгээрээс 28.8% нь буюу 286 нь цар тахлын хариу арга хэмжээнд хамаарч байна

74

79

315

Иргэний эрхийн
зохицуулалтыг хөндсөн

ТББ үйл ажиллагааны
орчныг хөндсөн

Хүний эрхийн
зохицуулалтыг хөндсөн

Цар тахлын үеийн мэдээлэл авах эрхийн
зохицуулалт нь:

- Ердийн үеийн мэдээлэл авах эрхийн зохицуулалтыг хязгаарлаагүй,
- Гамшгаас хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар үнэн зөв, бодит мэдээлэл авах иргэний болон хуулийн этгээдийн эрхийг баталгаажуулсан,
- Төр цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүл мэндээ хамгаалах арга замын талаар үнэн зөв, бодит мэдээллээр иргэдийг тогтмол, шуурхай, хүртээмжтэй хангахаар үүрэгжүүлсэн бөгөөд бэлэн байдлын үед төрийн байгууллагатай харилцах, үйлчилгээ авах журмыг тодорхойлсон

Төр иргэдийг үнэн зөв, бодит мэдээллээр
хангахтай холбоотой үүссэн асуудлууд

- Мэдээллийн уялдаа холбоо, найдвартай байдал хангалтгүй.
- Мэдээллийн хүртээмжтэй байдал хангалтгүй.
- Мэдээллийн эх сурвалжийг хязгаарлах.
- Хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлах.

“Үзэл бодлоо илэрхийлэх эрх” - гарсан зөрчил

Зөрчил

2021 онд

Зөрчлийн тухай хуулийн 5.13.1	1962 зөрчил
Эрүүгийн хуулийн Худал мэдээлэл тараах гэмт хэрэгтэй холбоотой	583 гомдол
Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд үзэл бодлоо илэрхийлэх эрх	46 зөрчил
Цар тахалтай холбоотой албаны мэдээ, мэдээллийг хэрэглэгчийн сэтгэгдэл авах боломжгүй тохиргоотойгоор нийтлэх зөвлөмжийг	424 цахим хуудасны хэрэглэгч
Иргэний эрхийн зөрчил	233 зөрчил
Зөрчлийн тухай хуулийн 5.13.1	1962 зөрчил

Илт худал мэдээлэлтэй холбоотой зөрчлүүдээс дурдвал


1. Цар тахалтай холбоотой албаны мэдээ, мэдээллийг хэрэглэгчийн сэтгэгдэл авах боломжгүй тохиргоотойгоор нийтлэх зөвлөмжийг 424 цахим хуудасны үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлсэн нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийг нийтлэг байдлаар хязгаарлах нийтийн эрүүл мэндийг цар тахлаас хамгаалах гарцаагүй шаардлагатай гэж үзэх хангалттай үндэслэлгүй,
2. Тусгаарлалтад байгаа хүмүүсийн үзэл бодлоо илэрхийлэх, Улсын онцгой комиссын үйл ажиллагааг шүүмжлэх эрх, боломжийг үндэслэлгүйгээр хязгаарласан тохиолдол гарсан,
3. Тусгаарлалтад байсан иргэд групп чат үүсгэн харилцахыг хориглосон,
4. Эвлэлдэн нэгдэж тайван замаар цуглаан хийж цалин нэмэхийг шаардаж буй эмч нарыг эх орноосоо урвах гэмт хэрэгт буруутгасан гэх мэт ноцтой зөрчлүүд гарсан.

Жагсаал, цуглааны талаарх мэдээлэл

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын тайван жагсаал, цуглаан хийх эрхийг зөрчсөн 55 (иргэний эрхийн зөрчлийн 24%) зөрчил илэрсэн. Жагсаал, цуглаан хийх эрхийн дараах зөрчлүүд түгээмэл гарч байна:

- Жагсаалыг цагдаагийн хүчээр албадан тараах, зарим тохиолдолд жагсагчдыг баривчлах, жагсаал, цуглаанд ашиглах эд материал, хэрэгслийг хураах, гэх мэт арга хэмжээ авагдсан байна.
- Жагсаал зохион байгуулагчдыг үндэслэлгүйгээр саатуулах, албадан авч явах, мэдүүлэг авах, зөрчлийн тухай хуулиар торгох, гэх мэт.
- Жагсагчдыг айлган сүрдүүлэх мохоох мэдэгдэл, оролдлогууд гарсан.
- Жагсаал цуглаан зохион байгуулагчид, оролцогчдод ялгавартай хандсан асуудал гарсан.
- Халдвар хамгааллын дэглэм сахиж, хүн хоорондын зайг баримтлан явагдаж байгаа тайван жагсаал, цуглаанд КОВИД-19-ын халдвартай хүн оролцсон үндэслэлээр цагдаагийн алба хаагчид иргэдийг олноор нь саатуулж, тэдний нэр, регистр, оршин суугаа хаяг болон харилцах утасны талаарх мэдээллийг авсан.

ЦЕГ-ын мэдээллээр:



жагсаал зохион
байгуулагдсан

Хүний эрхийг
зөрчиж таслан
зогсоогдсон

Цар тахлын үед ТББ-ын орчин

- ТББ-ын үйл ажиллагааны орчныг тусгайлан зохицуулсан ямарваа нэг эрх зүйн акт цар тахлын үед батлагдаагүй.
 - 2020.11.11 – Анх бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлсэн ба үүнтэй холбоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоосон. Үүнд:
 - нэг дор 10-аас дээш хүн цугларахгүй байх,
 - хөдөлгөөний цагийн хязгаарлалт тогтоох,
 - бүх нийтийн бэлэн байдлын үед хуулийн этгээдийн үйл ажиллагааг хязгаарлах,
 - зөвхөн үйл ажиллагааг нь хязгаарлаагүй байгууллааг ажилтан тогтоосон цагийн хязгаараар хөдөлгөөнд оролцох гэх мэт
 - КОВИД-19-ын хуульд - "Засгийн газар цар тахлын үед хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгж, байгууллага, цалин, орлого нь тасалдсан иргэдэд зохих дэмжлэг үзүүлнэ" гэж заасан. Үүний хүрээнд:
 - “Коронавируст цар тахлын эсрэг 5.1 их наяд төгрөгийн багц хөтөлбөр”
 - “Эрүүл мэндээ хамгаалж эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”
 - Цахилгаан, дулаан, усны төлбөрийг төр хариуцах
 - Татвар, нийгмийн даатгал төлөгч аж ахуйн нэгжийг татвар, торгууль, алдангиас чөлөөлөх.
- Зарим салбарт хөнгөлөлттэй зээл гэх мэт бусад арга хэмжээ хэрэгжсэн ч ТББ-уудад тусдаа дэмжлэгийн арга хэмжээ байхгүй.
- Төрөөс ААНБ-уудад үзүүлэх дэмжлэгийн арга хэмжээ нь томоохон ТББ-уудад дэмжлэг болж чадсан бол жижиг ТББ-уудад дэмжлэгийн нөлөө бага байсан гэж үзэх үндэстэй байна.